



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/78

Мөрөн сум

Хичээлийн жилийн бүтцэд
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутаг дахь зуд, цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал, томуугийн тархалттай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/244 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц”-ийн 25 дахь долоо хоногийн Даваа гараг буюу 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2023 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн Бямба гарагт, Баасан гараг буюу 2023 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2023 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн Бямба гарагт тус тус шилжүүлэн зохион байгуулсугай.

2. Энэхүү хичээл, сургалтын үйл ажиллагааны зохицуулалтыг бүх ерөнхий боловсролын сургуулиудад мэдэгдэж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН